



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

### Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх болзолт уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 3/03 дугаар тогтоолоор батлагдсан “Баянгол дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багшийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх, мэргэжил сонголтыг оновчтой болгох зорилгоор дүүргийн хэмжээнд “Элсэлтийн ерөнхий шалгалт-2022” болзолт уралдааныг зохион байгуулсугай.

2.Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын төлөвлөгөө, удирдамж, шаардагдах зардлын төсвийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх болзолт уралдаанд шаардагдах зардлыг холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газар (Б.Нарангэрэл)-т зөвшөөрсүгэй.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч Д.Жаргалсүрэнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.СУМЪЯАБААТАР



Баянгол дүүргийн Засаг даргын  
2022 оны 01 дугаар сарын 02 -ны өдрийн  
Ажл дугаар захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч

Гишүүд:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Боловсролын хэлтсийн Статистик мэдээ, хяналт үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

“Шинэ эрин” Олон улсын хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн захирал (зөвшилцсөнөөр)

Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд

Нарийн бичгийн дарга:

Боловсролын хэлтсийн Суурь, бүрэн дунд болон албан бус боловсрол хариуцсан мэргэжилтэн